

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/03/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойр хот
2022 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас: 70543156 Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр
Утас: 70543179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Батсайхан
Утас: 70543179 Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	13
4.1 Залруулсан алдаа	13
4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй	13
4.3 Албан шаардлага өгөгдөөгүй	13
4.4 Зөвлөмж	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АИТХТ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
ГСА	Говьсүмбэр аймаг
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

Г АЙМГИЙН "ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН САН"-ГИЙН ТӨСВИЙН
ЗАХИРАГЧ Г.БАТЗАМ ТАНАА

2022.03.25 № 49
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Орон нутгийн хөгжлийн сан"-гийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

078020176

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *Б.Сарантуяа* Б.САРАНТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	312,613,207.41	301,296,728.04
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	181,586,287.41	193,833,900.04
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	181,586,287.41	193,833,900.04
31210	Төгрөг	181,586,287.41	193,833,900.04
31211	Төрийн сангийн харилцах	181,586,287.41	193,833,900.04
33	АВЛАГА	47,362,828.00	47,362,828.00
33500	Бусад авлага	47,362,828.00	47,362,828.00
33510	Байгууллагаас авах авлага	47,362,828.00	47,362,828.00
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	83,664,092.00	60,100,000.00
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/+ Бусад	83,664,092.00	60,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	312,613,207.41	301,296,728.04
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	16,367,927.00	0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	16,367,927.00	0
41300	Өглөг	16,367,927.00	0
41360	Бусад өглөг	16,367,927.00	0
41361	Байгууллагад төлөх өглөг	16,367,927.00	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	296,245,280.41	301,296,728.04
51	Засгийн газрын хувь оролцоо	296,245,280.41	301,296,728.04
51200	Хуримтлагдсан үр дүн	296,245,280.41	301,296,728.04
51210	Өмнөх үеийн үр дүн	1,014,627,838.80	296,245,280.41
51220	Тайлант үеийн үр дүн	-718,382,558.39	5,051,447.63
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ Ө МЧИЙН ДҮН VI=IV+V	312,613,207.41	301,296,728.04

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	623,064,315.00	983,618,768.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0	2,471,450.00
120	Нийтлэг татварын бус орлого	0	2,471,450.00
120009	Бусад орлого	0	2,471,450.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	623,064,315.00	981,147,318.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	549,064,315.00	961,147,318.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	549,064,315.00	961,147,318.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	74,000,000.00	20,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,000,000.00	20,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,341,446,873.39	978,567,320.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,341,446,873.39	978,567,320.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,341,446,873.39	978,567,320.37
2104	Хангамж, бараа материалын зардал	1,048,609,595.00	570,708,080.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	1,048,609,595.00	570,708,080.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	292,837,278.39	407,859,240.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	292,837,278.39	407,859,240.37
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-718,382,558.39	5,051,447.63
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-718,382,558.39	5,051,447.63

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	1,009,090,588.80	1,009,090,588.80
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	5,537,250.00	5,537,250.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	1,014,627,838.80	1,014,627,838.80
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-718,382,558.39	-718,382,558.39
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0	0	296,245,280.41	296,245,280.41
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0	0	296,245,280.41	296,245,280.41
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0	0	296,245,280.41	296,245,280.41
19	Тайлант үеийн үр дүн	0	0	5,051,447.63	5,051,447.63
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	0	0	301,296,728.04	301,296,728.04

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

		/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	623,064,315.00	981,147,318.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	623,064,315.00	981,147,318.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	549,064,315.00	961,147,318.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	549,064,315.00	961,147,318.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	74,000,000.00	20,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	74,000,000.00	20,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	292,837,278.39	407,859,240.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	292,837,278.39	407,859,240.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	292,837,278.39	407,859,240.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	292,837,278.39	407,859,240.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	292,837,278.39	407,859,240.37
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	330,227,036.61	573,288,077.63
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	275,945,799.00	561,040,465.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	275,945,799.00	561,040,465.00
2200	Дотоод эх үүсвэрээр	275,945,799.00	561,040,465.00
223001	Бусад хөрөнгө	275,945,799.00	561,040,465.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-275,945,799.00	-561,040,465.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	54,281,237.61	12,247,612.63
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	127,305,049.80	181,586,287.41
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	181,586,287.41	193,833,900.04

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /				
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,162,733,600.00	968,899,705.37	193,833,894.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	553,392,700.00	407,859,240.37	145,533,459.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	553,392,700.00	407,859,240.37	145,533,459.63
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	553,392,700.00	407,859,240.37	145,533,459.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	553,392,700.00	407,859,240.37	145,533,459.63
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	609,340,900.00	561,040,465.00	48,300,435.00
223001	Бусад хөрөнгө	609,340,900.00	561,040,465.00	48,300,435.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,162,733,600.00	981,147,318.00	181,586,282.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	961,147,300.00	961,147,318.00	-18.00
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	961,147,300.00	961,147,318.00	-18.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,000,000.00	20,000,000.00	0.00
320001	Орон нутгийн төсвөөс	20,000,000.00	20,000,000.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	181,586,300.00	0	181,586,300.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	181,586,300.00	0	181,586,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	181,586,287.41	-181,586,287.41
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	193,833,900.04	-193,833,900.04

3. Аудитын тайлан

3.10 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/104 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.11 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Говьсүмбэр аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн эрхэм зорилго нь "Ард иргэдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах"-д оршино гэжээ.

Тайлан хугацаанд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна.

1. Нийтийн эзэмшлийн гудамж талбайд тохижилтын ажлууд, зураг төсвийн ажлуудыг гүйцэтгэж, ард иргэдийн ая тухтай орчинд амьдрах, хүүхэд залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх боломжоор хангах

2. Аймгийн дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, аймгийн эдийн засаг, нийгмийг дээшлүүлэх

3. Төрийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, орон нутгийн өмчийн барилга байгууламжийг засварлаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитор нь тайлант онд тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.12 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.13 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 1,341,446.8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 13,414.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,731.5 мянган төгрөгөөр тогтоосон

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.14 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,316.5 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, бараа материал, өглөг, засгийн газрын оролцоо дансад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	181,586.3	193,833.9	12,247.6
Авлага	47,362.8	47,362.8	0.0
Урьдчилгаа			0.0
Бараа материал	83,664.1	60,100.0	-23,564.1
Үндсэн хөрөнгө			0.0
Нийт хөрөнгө	312,613.2	301,296.7	-11,316.5
Өр төлбөр	16,367.9		-16,367.9
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	296,245.3	301,296.7	5,051.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	312,613.2	301,296.7	-11,316.5

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 193,833.9 мянган төгрөг болж 12,247.6 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахлын улмаас хөтөлбөрөөс санхүүжих арга хэмжээг дутуу хэрэгжүүлж, хэмнэсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдэлд тайлагнасан байгууллагаас авах авлагын 47,362.8 мянган төгрөг нь ажлын санхүүжилтийг урьдчилж олгосон боловч ажил нь хийгдээгүйгээс үүссэн авлага, он дамжсан, насжилт өндөртэй авлага байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэл 60,100.0 мянган төгрөг болж 23.546.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг хүлээлгэн өгсөн, тайлант оны ажил дутуу хэрэгжсэн зэрэгтэй холбоотой байна.

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэл 83,664.1 мянган төгрөг байснаас өмнөх оны үлдэгдэл 83,664.1 мянган төгрөгийн 4 ажлыг АИТХТ-ийн 2021.12.30-ны өдрийн 46 дугаар тогтоолоор ашиглагч байгууллагад нь шилжүүлж, тайлант онд олгосон 5 зураг, төсвийн ажлын урьдчилгаа 60,100.0 мянган төгрөгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Тайлант онд өр төлбөрийн дансыг үлдэгдэлгүй тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 301,296.7 мянган төгрөг болж 5,051.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант хугацааны үр дүнгээр нэмэгдсэн байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 360,554.4 мянган төгрөгөөр буюу 57.8 хувиар нэмэгдсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь ОНХНС-гийн санхүүжилт 412,083.0 мянга, татварын бус орлого 2,471.4 мянга, нийт 414,554.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, орон нутгийн төсвийн санхүүжилт 54,000.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Энэ нь орон нутгийн хөгжлийн сангаар хийгдэх хөрөнгө оруулалт болон хөтөлбөрийн хэмнэлт үүсэж эхний үлдэгдлээс санхүүжих ажил нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 362,879.5 мянган төгрөгөөр буюу 27.0 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь бараа материал шилжүүлсэн зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд байна.

Энэ нь тайлант онд хөрөнгө оруулалтын ажил өмнөх оноос хасагдаж, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардал өмнөх оноос нэмэгдсэн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант онд залруулга хийгдээгүй байна.

3.15 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд 982,794.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалтын ажлыг 20,000.0 мянга, шинээр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлыг 98,700.0 мянга, их засварын ажлыг 70,744.2 мянга, нийт 189,444.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн баяр наадмын зардлыг 9,505.0 мянган төгрөгөөр бууруулж, нийт 1,162,733.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх "70,503-орон нутгийн зорилтод хөрөнгө оруулалт" 1 хөтөлбөрийн хүрээнд 80918 бусад арга хэмжээг санхүүжүүлэхээр 609,340.9 мянга, 83,112-хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал арга хэмжээг санхүүжүүлэхээр 553,392.7 мянга, нийт 1,162,733.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 961,147.3 мянган төгрөгийг ОНХНС-гаас, 20,000.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс,

181,586.3 мянган төгрөгийг ОНХС-гийн эхний үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр ОНХНС-гаас санхүүжилт 961,147.3 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжилт 20,000.0 мянга, нийт 981,147.3 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Тайлант онд хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд 968,899.7 мянган төгрөг зарцуулж, 193,833.9 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 968,899.7 мянган төгрөг буюу 83.3 хувьтай байгаа нь тайлант онд хөрөнгө оруулалтын ажил он дамжсан, хөтөлбөр төсөл, арга хэмжээний зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайланд ОНХНС-гаас санхүүжилт 961,147.3 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжилт 20,000.0 мянга, бусад орлого 2,471.4 мянга, нийт 983,618.7 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд ОНХНС-гаас санхүүжилт 961,147.3 мянга, орон нутгийн төсвөөс санхүүжилт 20,000.0 мянга, нийт 981,147.3 мянган төгрөгийн санхүүжилтийг тайлагнасан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн ОНХС нь нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

3.16 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

3.17 3.8 Аудитын гол асуудал

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь он дамжсан 47,362.8 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг урьдчилгаа санхүүжилт олгож одоог хүртэл ажлыг хүлээн аваагүй, авлагыг барагдуулж ажиллаагүй байна.

3.18 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг

хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Говьсүмбэр аймгийн "Орон нутгийн хөгжлийн сан" нь 2021 онд нийт 2,233,239.6 мянган төгрөгийн 83 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь үнэн зөв, бүрэн мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.19 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 111,995.3 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс 77,495.3 мянган төгрөгийн 3 зөрчилд 2 албан шаардлага өгч, 34,500.0 мянган төгрөгийн 5 зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгсөн байна.

Аудитаар өгөгдсөн зөвлөмж, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	34,500.0	4	34,500.0	-	-	-
Албан шаардлага	2	77,495.3	2	77,495.3			
Нийт дүн	6	111,995.3	6	111,995.3	-	-	-

3.20 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 37,126.1 мянган төгрөгийн 1 алдаа, зөрчил илэрсэнд зөрчлийг давтан гаргахгүй байх 1 албан шаардлага өглөө.

4.1 Залруулсан алдаагүй

4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй

4.3 Албан шаардлага

4.3.1 Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүнг 37,126.1 мянган төгрөгөөр дутуу шивсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг тус тус зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж өгөгдөөгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.